

АЗИ, АФРИКИЙН ЭВ САНААНЫ НЭГДЛИЙН СОЦИАЛИСТ ОРНЫ ХОРООДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

Ази африкийн эв санааны нэгдлийн социалист орны хороодын төлөөлөгчдийн XIII зөвлөлдөх уулзалт энэ арван нэгдүгээр сарын 18-19-нд Улаанбаатар хотноо болов. Уулзалтад БНБАУ, БНУАУ, БНСВУ, БНАГУ, БНКАУ, БНАЛАУ, БНМАУ, БНПАУ, ЗСБНХУ, БНСЧСУ-ын төлөөлөгчид болон Ази, африкийн ард түмний эв санааны нэгдлийн байгууллагын төлөөлөгч оролцов.

Орчин үеийн улс төр, төрийн гарамгай зүтгэлтэн, энх тайвны төлөө цогтой тэмцэгч Л.И.Брежневийн гэгээн дурсгалыг уулзалтад оролцогчид хүндэтгэв.

Тус уулзалтад оролцогчид энх тайван, намжмал байдал, ази, африкийн ард түмний үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө нийтийн тэмцэлтэй Ази, африкийн эв санааны нэгдлийн социалист орны хороодын хамтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудал хэлэлцэж, олон улсын цаг үеийн асуудлаар саналаа солилцов.

Хэлэлцсэн бүх асуудлаар уулзалтад оролцогчдын үзэл, байр суурь нэг байв. Империализмын түрэмгий хүч, юуны өмнө АНУ-ын буруугаар дэлхий дахины байдал хурцдаж, түгшүүртэй байдал даамжирч байгаад сэтгэл түгшиж байгаага тэд илэрхийлэв.

ЗХУКН-ын XXVI их хурлаар дэвшүүлсэн 80-аад оны энх тайвны программ, зөвлөлтийн удирдагчдын оновчтой чухал санаачилга, саналуудыг хэрэгжүүлэх нь бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж бэхжүүлэх, цөмийн сүйрлийн аюул заналыг бууруулан зайлуулах үйлсэд шийдвэрлэх ач холбогдолтой болохыг, уулзалт онцлон тэмдэглэв.

Уулзалтад оролцогчид «Энх тайван ба амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» Дэлхий дахины Ассамблейг Прага хотноо 1983 оны зургадугаар сард хуралдуулахын чухлыг тэмдэглэв.

Уулзалтад оролцогчид Ази тивийн байдлыг авч хэлэлцэхдээ Алс Дорнодод итгэлцийн арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх талаархи Зөвлөлт Холбоот Улсын санал чухал ач холбогдолтойг тэмдэглээд, Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх конвенц байгуулах тухай БНМАУ-ын цаг үеэ олсон, санаачилгыг санал нэгтэй дэмжиж байгаага илэрхийлэв. Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгоход чиглэсэн БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын саналыг дэмжив.

Уулзалтад оролцогчид Энэтхэг-хятадын хойгийн орнууд болон АСЕАН-ы гишүүн улсуудын хооронд яриа хэлэлцээ эхэлж байгаа нь Зүүн өмнөд Ази болон нийт Ази тивийн энх тайван аюулгүй байдлыг хангах эрх ашигт нийцэж байна гэж сайшаан тэмдэглэв.

АНУ-ын империализмын шууд өөгшүүлгээр Ойрхи Дорнодод израилийн дайнчдын үйлдэж байгаа аймаглан устгах, зэрлэг балмад ажиллагааг уулзалтаас эрс шийдвэртэй буруушаав.

Уулзалтад оролцогчид төр улсаа эмхлэн байгуулах палестины ард түмний хууль ёсны салшгүй эрхийг хүндэтгэх, израилийн түрэмгийлэгчдийг арабын эзлэгдсэн бүх нутаг дэвсгэрээс нэн даруй гаргах, Ливаны тусгаар тогтнол, бүрэн эрхийг хангахын чухлыг тэмдэглэв.

Уулзалтад оролцогчид Африкийн улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолоо бэхжүүлэх болон нийгмийн дэвшлийн төлөө тэмцэлтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлэв. Фронт хавийн улсуудад болон Африкийн Үндэсний Конгресс, Баруун өмнөд Африкийн Ардын байгууллагын (СВАПО) чөлөөлөх хөдөлгөөнд цаашид ч идэвхтэй дэмжлэг үзүүлэх нь чухал байгааг тэд тэмдэглэв.

Уулзалтад оролцогчид дайны эсрэг хөдөлгөөнийг идэвхжүүлэх, улс түмний энх тайван. Найрамдлын төлөө ариун тэмцэлд нэгдэл нягтралаа бэхжүүлэн, хамтын ажиллагаагаа цуцалтгүй өргөжүүлэхийг хоёр тивийн олон нийтэд уриалав.

Тус уулзалтыг амжилттай зохион байгуулж, зочломтгой сайхан хүлээн авсан Ази, Африкийн эв санааны нэгдлийн монголын хооронд уулзалтад оролцогчид гүн талархал илэрхийлэв.

Улаанбаатар хот.
1982 оны арван нэгдүгээр сарын 19.